**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 01 өдөр — Дугаар А/251 — Улаанбаатар хот

Шуурхай штаб байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн $27^1$.1.6, 32 дугаар зүйлийн 32.1.1, Улсын Онцгой комиссын 2025 оны нэгдүгээр тогтоол, тавдугаар тушаал, Нийслэлийн Онцгой комиссын даргын 2025 оны 02 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цаг уур, орчны шинжилгээний газрын цаг агаарын урьдчилсан мэдээгээр 2025 оны 7 дугаар сард төвийн бүс нутаг, Улаанбаатар хот орчмоор олон жилийн дунджаас дулаан, огцом халах, огцом сэрүүсэх, түр зуурын усархаг аадар бороо орох, борооны өмнө хүчтэй салхи, шуургатай байх, улаан бурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах үүрэг бүхий Онцгой комиссын Шуурхай штабыг байгуулсугай.

2.Шуурхай штабын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Шуурхай штабын жижүүрийн хуваарийг 10 хоног бүрээр баталж, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Онцгой байдлын хэлтэс (хурандаа Б.Батбилэг)-т, жижүүрээр ажилласан албан хаагчдад холбогдох хууль, журмын дагуу ажлын гүйцэтгэлээр хоолны мөнгө олгохыг Засаг даргын Тамгын газар (О.Батмөнх)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Н.МАНДУУЛ

1525010741

D:\Bichig hereg\2025\Zahiramj\zahiramj 2025.docx

Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн А/251 дугаар захирамжийн хавсралт

## ДҮҮРГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

| | | |
|---|---|---|
| Шуурхай штабын дарга: | З.Бямбажав | Засаг даргын орлогч |
| Орлогч дарга: | Л.Цэеэрэгзэн | Дүүргийн менежер |
| | Б.Батбилэг | Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа |
| | Х.Ганцэцэг | Чингэлтэй Нэгдсэн эмнэлгийн захирал |
| Гишүүд: | Т.Батцэцэг | Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга |
| | Г.Энхбаяр | Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга |
| | Г.Хурцбаяр | Засаг даргын Тамгын газрын Хууль, эрхзүйн хэлтсийн дарга |
| | М.Навчаа | Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга |
| | Ц.Батжанцан | Засаг даргын Тамгын газрын Хотын стандарт, тохижилт, нийтийн ахуйн хэлтсийн дарга |
| | Б.Амгалан-Энх | Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа |
| | Г.Золжаргал | Дүүргийн Замын цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа |
| | Ж.Тамир | Дүүргийн Газар зохион байгуулалтын албаны дарга |
| | Э.Ганчимэг | "Тохижилт үйлчилгээний" ХХК-ийн захирал |

| | | |
|---|---|---|
| | Б.Уянга | “Наши трейд” ХХК-ийн захирал |
| | Ш.Мөнх-Оргил | Дүүргийн Нийтлэг үйлчилгээний ОНӨТҮГ-ын дарга |
| | Э.Онон | Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨТҮГ-ын захирал |
| | Ж.Саруул | “УБЦТС” ХХК-ын Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төвийн дарга |
| Нарийн бичгийн дарга: | Г.Батболд | Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн замын байгууламж хариуцсан мэргэжилтэн |
| | П.Эрхэмбаяр | Чингэлтэй Нэгдсэн эмнэлгийн орлогч дарга |
| | Б.Номин-Эрдэнэ | Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, ахмад |